

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/5/СТА-ТЭЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням Утас: 260949 Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn Аудитын менежер: Г.Гүнжидмаа Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Ахлах аудитор: А.Даваадорж Аудитор: Н.Баттөгөлдөр Утас: 260512 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn battuguldurn@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал....	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	13
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	13
3.5.3 Авлага	14
3.5.4 Урьдчилгаа	14
3.5.6 Бараа материал.....	15
3.5.7 Үндсэн хөрөнгө	16
3.5.8 Өр төлбөр	16
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Шилэн дансны мэдээлэл.....	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
Зөвлөмж	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗГБНҮГ	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Ц.НЯМДОРЖ ТАНАА

2021.04.26 № 1308

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,178,219.4	917,403,303.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,318,151.1	59,192,582.6
33	АВЛАГА	893,038.0	12,650,730.6
34	УРЬДЧИЛГАА	352,154.7	3,554,931.6
35	БАРАА МАТЕРИАЛ	2,614,875.6	55,937,215.5
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	786,067,843.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	63,643,021.8	375,878,318.0
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	500.0
37300	Урт хугацаат зээл	0.0	500.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	63,643,021.8	375,877,818.0
39200	Биет хөрөнгө	55,982,717.3	245,393,504.1
39300	Биет бус хөрөнгө	7,660,304.4	124,595,835.9
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	5,888,478.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	75,821,241.1	1,293,281,621.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,068,750.4	131,103,472.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,068,750.4	38,729,351.5
41300	Өглөг	785,010.1	35,172,314.0
41400	Урьдчилж орсон орлого	1,283,740.2	3,557,037.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	92,374,121.3
42200	Урт хугацаат зээл	0.0	92,374,121.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	73,752,490.8	1,162,178,148.8
51	Засгийн газрын хувь оролцоо	73,752,490.8	1,158,655,113.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	39,892,386.7	47,976,898.1
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.0	227,806,661.7
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	757,597.4	3,296,109.7
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	3,165,985.8	58,154,363.4
51200	Хуримтлагдсан үр дүн	2,870,842.1	282,891,430.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,065,678.7	55,976,990.2
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.0	482,552,660.5
52	Хяналтын бус хувь оролцоо	0.0	3,523,035.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	75,821,241.1	1,293,281,621.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	78,813,081.6	458,164,620.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,243,796.5	66,681,666.6
120	Нийтлэг татварын бус орлого	48,763,996.5	66,677,787.2
121	Хөрөнгийн орлого	479,800.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	3,879.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	29,569,285.1	391,482,954.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	80,079,344.6	193,775,295.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	44,594,122.3	193,485,451.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,020,100.7	174,153,932.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,933,740.9	21,739,866.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,598,030.5	2,760,685.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,664,039.9	4,125,593.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,992,774.2	3,434,603.9
2105	Норматив зардал	47,178.9	102,606.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,750,754.9	2,421,266.5
2107	Томилолт, зочны зардал	1,989,377.9	893,732.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,853,773.0	25,942,119.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,190,430.5	112,733,457.9
212	ТАТААС	28,082.7	571,561.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,545,938.9	18,759,958.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,485,222.3	289,843.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(1,266,263.0)	264,389,325.3
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	4,188.1	1,185,918.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	46,411.8	740,057.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(1,308,486.7)	264,835,186.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	74,253,549.9	0.0	74,253,549.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	49,830.1	0.0	49,830.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	74,303,380.0	0.0	74,303,380.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	757,597.4	0.0	757,597.4
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	(1,308,486.7)	0.0	(1,308,486.7)
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	73,752,490.8	0.0	73,752,490.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	823,393,302.4	0.0	823,393,302.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	897,145,793.2	0.0	897,145,793.2
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	15,877.5	0.0	15,877.5
17	Өмчид гарсан өөрчлөлт	595,344.3	0.0	595,344.3
18	Зарласан ногдол ашиг	(414,052.2)	0.0	(414,052.2)
19	Тайлант үеийн үр дүн	264,835,186.0	0.0	264,835,186.0
20	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,162,178,148.8	0.0	1,162,178,148.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	46,428,854.6	672,676,048.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,430,070.1	280,201,942.9
120	Нийтлэг татварын бус орлого	15,430,070.1	280,201,942.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,998,784.5	392,474,105.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,136,493.0	265,442,174.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,136,493.0	265,442,174.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,452,632.4	235,810,153.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,907,300.4	48,217,157.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,678,610.4	10,775,147.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,662,001.8	23,188,143.7
2104	Хангамж, бараа материалын зардал	4,054,023.8	11,858,303.6
2105	Норматив зардал	78,050.3	85,464.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,285,096.9	2,842,622.0
2107	Томилолт, зочны зардал	1,956,775.8	1,033,824.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,739,240.5	132,620,820.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,091,532.5	5,188,670.4
212	ТАТААС	0.0	4,454,700.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,683,860.6	25,177,320.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,292,361.6	407,233,873.6
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	2,489,116.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,578,852.5	356,322,527.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,578,852.5	356,322,527.6
2200	Дотоод эх үүсвэрээр	6,578,852.5	356,322,527.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(6,578,852.5)	(353,833,411.6)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(35,556.7)	(2,526,030.6)
14	Бусад эх үүсвэр	4,188.1	1,454,058.4
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	39,744.8	3,980,089.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(2,322,047.6)	50,874,431.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,640,198.7	8,318,151.1
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,318,151.1	59,192,582.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	433,011,892.2	410,339,938.6	22,671,953.6	94.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,263,014.5	46,610,308.8	15,652,705.7	74.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,427,180.8	35,256,479.0	15,170,701.8	69.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,525,490.5	13,129,051.3	396,439.2	97.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,804,766.6	1,728,857.7	75,908.9	95.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,689,354.0	1,462,857.9	226,496.1	86.6
2104	Хангамж, бараа материалын зардал	1,040,816.9	997,208.7	43,608.2	95.8
2105	Норматив зардал	19,238.2	18,930.3	307.9	98.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	655,983.5	648,151.4	7,832.1	98.8
2107	Томилолт, зочны зардал	1,692,101.5	998,210.6	693,890.9	59.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,163,980.9	11,359,119.3	4,804,861.6	70.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,835,448.7	4,914,091.8	8,921,356.9	35.5
212	ТАТААС	8,455,373.1	8,455,373.1	0.0	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,429,952.0	4,429,952.0	0.0	100.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,025,421.1	4,025,421.1	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,380,460.6	2,898,456.7	482,003.9	85.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,494,046.8	1,413,129.7	80,917.1	94.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,886,413.8	1,485,327.0	401,086.8	78.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	370,748,877.7	363,729,629.8	7,019,247.9	98.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	433,011,892.2	410,585,717.5	22,426,174.7	94.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	426,767,420.4	404,704,499.0	22,062,921.4	94.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,244,471.8	5,881,218.5	363,253.3	94.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	185,434.0	(185,434.0)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	189,896.8	(189,896.8)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	10	10	0.0	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	851	846	5.0	99.4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	851	846	5.0	99.4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,624,154.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,566,264.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,340,682.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,847.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,109.8
2104	Хангамж, бараа материалын зардал	179,067.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	431,425.5
2107	Томилолт, зочны зардал	11,919.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,853.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	341,459.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	225,581.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,400.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	210,181.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	57,890.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,746,104.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,746,104.4
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	121,950.1
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	95,753.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	217,703.9

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд удирдлагын болон дээд шатны төсвийн захирагчийн дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор Н.Баттөгөлдөр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн ХЭГ/894 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар үйл ажиллагааны эрхэм зорилгоо мэргэшлийн өндөр түвшний, цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр Ерөнхий сайд, Танхимыг шуурхай хангах, Засгийн газрын тасралтгүй, хэвийн, үр ашигтай ажиллагааны зохистой орчин бүрдүүлэхэд оршино гэж тодорхойлсон ба эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Засгийн газрын бодлого, шийдвэрийг боловсруулах, хуралдаанд бэлтгэх болон яам, Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Ерөнхий сайд, Танхим, бүх шатны Хурал, Засаг даргыг орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, нутгийн удирдлагын чиглэлээр өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэгээр шуурхай хангах, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааны үр нөлөөтэй, хэвийн жигд ажиллагааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;
- Танхимын хуралдааны зохион байгуулалт, хүний нөөцийн болон захиргааны удирдлагын манлайллыг хангах, төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагчид санхүүгийн үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналт, шалгалт, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үр дүнд өгөх үнэлгээний үр ашгийг дээшлүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах;
- Төрийн мэдээллийн сүлжээг хөгжүүлэх зохион байгуулалт, мэргэшил-арга зүйн удирдлагаар хангах;
- Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны талаар олон нийтийг нээлттэй, шуурхай мэдээллээр тогтмол хангах, олон нийттэй харилцах;

- Засгийн газраас явуулах шинэчлэлийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүй, удирдлагын дэмжлэг үзүүлэх;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын үйл ажиллагааны болон төрийн арга хэмжээний ёслолын үйл ажиллагааг эрхлэн явуулах;
- Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдад бодлогын зөвлөгөө өгөх, бүх талын үйлчилгээ, дэмжлэгээр хангах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоол “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай”;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-ын 9 дүгээр хавсралт “*Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ*”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 1 ахлах шинжээч, 2 шинжээч, нийт 3 ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллаж Дотоод аудитын төлөвлөгөөнд туссан 15 ажлаас 5 ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Ажлын гүйцэтгэл 33 хувьтай байгаа нь жилийн эцэст 1 шинжээчийг сэлгэн ажиллуулах шийдвэр гарснаас орон тоо дутуу ажилласан, мөн 1 ажилтны ажлын байрны тодорхойлолт дахь үндсэн чиг үүргийн ажлаас гадна давхар ажил хариуцан ажиллаж байгаа зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБООС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн 1,293,472.3 сая төгрөгийн 1 хувиар буюу 12,934.7 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,318.1 сая, эцсийн үлдэгдэл 59,192.5 сая төгрөг болж, 50,874.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/сая төгрөг/</i>			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	293.5	355.4	61.9	0.6
Банканд байгаа бэлэн мөнгө	8,024.6	51,541.9	43,517.3	87.1
Замд яваа мөнгөн хөрөнгө		0.5	0.5	0.0
Хадгаламж		7,294.7	7,294.7	12.3
Дүн	8,318.1	59,192.5	50,874.4	100.0

Эх сурвалж: ЗГХЭГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 34,385.7 сая төгрөг арилжааны банк дахь харилцах дансанд 16,508.7 сая төгрөг, барьцаа хөрөнгийн дансанд 105.5 сая төгрөг, техник хяналтын зардлын дансанд 542.0 сая төгрөг сангийн дансанд байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Монголын цахилгаан холбоо ХК-ийн 0.5 сая төгрөг байгаа ба салбаруудаас банкны гүйлгээ хаагдсаны дараа тушаасан орлоготой холбоотой үүссэн байна.

Хадгаламж дансанд Монголын цахилгаан холбоо ХК-ийн 3,694.7 сая төгрөг, Монгол шуудан ХК-ийн 3,600.0 сая төгрөгийн хадгаламж байна.

Тайлант онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын аж ахуйн нэгжүүд нэгтгэгдсэнээр мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 50,874.4 сая төгрөгөөр өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Үндэсний хөгжлийн газрын мөнгөн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа төсөл, арга хэмжээний техникийн хяналтын зардлаас хэмнэгдсэн 3,123.2 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба байгуулан 199.6 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардлыг санхүүжүүлсэн;
- Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар УТҮГ ажилтнуудын албан тушаалын цалин, нэмэгдлийг шинэчлэн батлахдаа үндсэн цалинг үндэслэлгүйгээр 20 хувиар нэмэгдүүлэн 2020 онд нэр бүхий 208 хүнд 324.5 сая төгрөгийг тооцож олгосон;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөлгүй 1,790.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн; */Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 1,689.1 сая, Үндэсний хөгжлийн газар 101.3 сая төгрөг/*

- Засгийн газрын тогтоосон хувь хэмжээнээс хэтрүүлэн 40.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон; /Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 16.6 сая, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан 23.5 сая, Удирдлагын академи..сая төгрөг/
- Нэмэлт санхүүжилтийн дансанд 299.1 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэн зарцуулсан; /Засгийн газрын авто бааз 63.4 сая, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар 235.7 сая төгрөг/
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 48.9 сая төгрөгийн зардал гаргасан; /Радио телевизийн сүлжээ 48.2 сая, Мэдээлэл технологийн үндэсний парк 0.5 сая, ЗГБНҮГ 0.2 сая төгрөг/
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар барьцаа хөрөнгийн дансанд 2015 онд хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 7.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй;
- Монгол шуудан ХК касс дахь бэлэн мөнгөний үлдэгдлийг сар бүр тоолж баталгаажуулаагүй.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 893.0 сая, эцсийн үлдэгдэл 12,650.7 сая төгрөг болж, 11,757.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	12.7	17.2	4.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	207.4	1,086.0	878.6
Татаас, санхүүжилтийн авлага	260.2	421.0	160.8
Дансны авлага /ТӨҮГ/	3.7	8,116.4	8,112.7
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/		450.0	450.0
Бусад авлага	409.0	2,560.1	2,151.1
Зээлийн авлага			
Дүн	893.0	12,650.7	11,757.7

Эх сурвалж: ЗГХЭГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 2,115.6 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн F-Zone хэрэглэгчийн болон бусад харилцагчаас авах 2007-2010 онуудад үүссэн 1,203.2 сая төгрөгийн авлага;
- Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2012-2018 онуудад Монголын цахилгаан холбоо ХК-иас авах түрээсийн гэрээний тооцоо болон хувь хүмүүсээс авах борлуулалтын орлогоос үүссэн 912.4 сая төгрөгийн авлага. Эдгээр нь хөрөнгийн үр ашиг буурах үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт:

- Монголын цахилгаан холбоо ХК 253.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна;
- Төрийн түүхийн музейн дансанд олон жил болсон, найдваргүй 6.2 сая төгрөгийн авлага байна;
- Радио телевизийн сүлжээ ТӨҮГ 4.1 сая төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлагыг бүртгээгүй байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 352.2 сая, эцсийн үлдэгдэл 3,554.9 сая төгрөг болж, 3,202.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	344.1	1,347.0	1,002.9
Бараа материал бэлтгэх урьдчилгаа		451.3	451.3

Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		1,744.6	1,744.6
Цалингийн урьдчилгаа		2.7	2.7
Томилолтын урьдчилгаа	8.1	9.3	1.2
Дүн	352.2	3,554.9	3,202.7

Эх сурвалж: ЗГХЭГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар дотоод албан томилолт болон гэрээний төлбөр нийт 784.2 сая төгрөгийг урьдчилгаа дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэсэн;
- Монгол шуудан ХК 2020 оны шинэ жилийн арга хэмжээнд зориулж Мондактс ХХК-д шилжүүлсэн 15.0 сая төгрөгийн арга хэмжээ зохион байгуулагдаагүй байхад төлбөрийг буцаан авч тооцоог хийгээгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 2,614.9 сая, эцсийн үлдэгдэл 55,937.2 сая төгрөг болж, 53,322.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал		2,687.2	2,687.2
Дуусаагүй үйлдвэрлэл		40,508.5	40,508.5
Бэлэн бүтээгдэхүүн	33.8	2,542.9	2,509.1
Хангамжийн материал	2,537.6	10,154.1	7,616.5
Биологийн хөрөнгө	43.5	44.5	1.0
Дүн	2,614.9	55,937.2	53,322.3

Эх сурвалж: ЗГХЭГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 53,322.3 сая төгрөгөөр өссөн нь Улсын Их Хурлын 2020 оны “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Ерөнхий сайдын багцаас Харилцаа холбоо мэдээллийн технологийн салбарын 10 байгууллага, Үндэсний хөгжлийн газар шилжин ирж нэгтгэгдсэнээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Худалдаж авсан 203.0 сая төгрөгийн бараа материалыг орлого авалгүй шууд зардлаар бүртгэсэн; /Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 194.8 сая, Радио телевизийн сүлжээ 8.2 сая/
- Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХХК-ийн 190.3 сая төгрөгийн худалдан авалтын гэрээний хугацаа хэтэрсэн, нэмэлт гэрээ байгуулаагүй байна.

Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 786,067.8 сая төгрөг байна.

Хүснэгт №5 Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/	-	7.7	7.7
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	-	786,060.1	786,060.1
Дүн	-	786,067.8	786,067.8

Эх сурвалж: ЗГХЭГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэлд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хөрөнгө оруулалт, их засварын ажлын 19,963.3 сая, Үндэсний хөгжлийн газрын 701,990.2 сая, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 50,499.2 сая, Бүх нийтийн

үйлчилгээний үүргийн сангийн 13,607.4 сая, Монгол шуудан ХК-ийн 7.7 сая, нийт 786,067.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний хөгжлийн газар болон Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 63,643.0 сая, эцсийн үлдэгдэл 375,877.8 сая төгрөг болж, 312,234.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	55,982.7	245,393.5	189,410.8
Биет бус хөрөнгө	7,660.3	124,595.8	116,935.5
Бусад хөрөнгө		5,888.5	5,888.5
Дүн	63,643.0	375,877.8	312,234.8

Эх сурвалж: ЗГХЭГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө 8,015.2 сая төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 515,431.3 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,319.9 сая, дахин үнэлгээгээр 977.7 сая, бусад байдлаар 3,864.9 сая, нийт 529,609.0 сая төгрөгөөр нэмэгдэж, худалдан борлуулсан 8.5 сая төгрөг, балансаас балансад шилжүүлсэн 2,405.4 сая, акталсан 1,108.0 сая, бусад байдлаар 664.0 сая, нийт 4,185.9 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХХК-ийн үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой 384.0 сая төгрөгийн гэрээний хэрэгжилт хангалтгүй байна;
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 75.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, тавилга эд хогшил бүртгэлтэй байна. /Удирдлагын академи болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 75.3 сая төгрөг/

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2,068.7 сая, эцсийн үлдэгдэл 131,103.4 сая төгрөг болж, 129,034.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	2,068.7	38,729.3	36,660.6
Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	179.9	179.9
Бараа үйлчилгээний зардлын өглөг	62.2	50.3	(11.9)
Татаас санхүүжилтийн өглөг		207.0	207.0
Бусад өглөг	722.8	34,735.1	34,012.3
Урьдчилж орсон орлого	1,283.7	3,557.0	2,273.3
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>		92,374.1	92,374.1
Урт хугацаат зээл		92,374.1	92,374.1
Нийт дүн	2,068.7	131,103.4	129,034.7

Эх сурвалж: ЗГХЭГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 16,580.8 сая төгрөгийн барьцаа, техник хяналтын зардлын төсөв, 14,119.7 сая төгрөгийн дансны өглөг, 4,471.8 сая төгрөгийн бусад өглөг, 3,557.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд нийт 92,374.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлын 41,862.2 сая төгрөгийн хойшлогдсон орлого, 3,283.3 сая төгрөгийн хойшлогдсон татварын өр, 40,370.3 сая төгрөгийн дамжуулан зээл;
- Монголын цахилгаан холбоо ХК-ийн ТУЗ-ийн 2007 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 79 дүгээр хурлын тогтоолоор Монголын цахилгаан холбоо ХК, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн хороонд хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой үүссэн 4,370.8 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр;
- Засгийн газрын авто баазын балансаас балансад шилжиж ирсэн 13 автомашины 2,483.1 сая төгрөгийн хойшлогдсон орлого;
- Мэдээлэл технологийн үндэсний паркийн 2010 онд үүссэн 4.4 сая төгрөгийн УБ дулааны сүлжээ ТӨХК-тай байгуулсан дулааны үр ашгийн төсөлд олгосон урт хугацаат зээл.

Аудитын илрүүлэлт:

Төрийн ордны мэдээлэл үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ Ковид-19 цар тахлаас үүдэн борлуулалтын орлого буурч улмаар тайлант онд ногдох хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг төлөх боломжгүйд хүрч өртэй гарсан байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 73,752.5 сая, эцсийн үлдэгдэл 1,158,655.1 сая төгрөг болж, 1,084,902.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	39,892.4	47,976.9	8,084.5	4.1
Өмч /төрийн/ /ТӨҮГ/		227,806.7	227,806.7	19.7
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	757.6	3,296.1	2,538.5	0.3
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	3,166.0	58,154.4	54,988.4	5.0
Хуримтлагдсан үр дүн	2,870.8	282,891.4	280,020.6	24.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,065.7	55,977.0	28,911.3	4.8
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		482,552.6	482,552.6	41.7
Дүн	73,752.5	1,158,655.1	1,084,902.6	100.0

Эх сурвалж: ЗГХЭГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь Улсын Их Хурлын 2020 оны “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Ерөнхий сайдын багцаас Харилцаа холбоо мэдээллийн технологийн салбарын 10 байгууллага, Үндэсний хөгжлийн газрыг ЗГХЭГ-ын багцад нэгтгэгдсэнээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан 433,011.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 62,263.0 сая төгрөгийг урсгал зардалд, 370,748.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 426,767.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 6,244.5 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 410,585.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,881.2 сая төгрөг бүрдүүлж, баталсан төлөвлөгөө 363.3 сая төгрөгөөр тасарсан нь Төр засгийн үйлчилгээ эрхлэх газар болон Үндэсний дата төвийн орлого буурсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 410,339.9 сая төгрөг буюу 94.8 хувьтай байгаа нь дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолын дагуу зарим зардлын санхүүжилтийг түр зогсоосонтой холбоотой байна. Урсгал төсвөөс дутуу зарцуулсан 6,472,6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 89 төсөл, арга хэмжээнд 370,748.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 363,920.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, 190.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 837.8 сая, Засгийн газрын нөөц санаас 191.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 52.8 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 664.0 сая, нийт 1,746.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 1,566.3 сая, хөрөнгийн зардалд 57.9 сая, нийт 1,624.2 сая төгрөг зарцуулсны 210.1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг: Тайлант онд Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын багцаас Харилцаа холбоо мэдээллийн технологийн салбарын 10 байгууллага, Үндэсний хөгжлийн газар, нийт 11 байгууллага Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэгдсэн.

Бусад асуудлын хэсэг: Засгийн газрын 2021 оны 91 дүгээр тогтоолоор Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2021 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 5 дугаар сарын 8-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн.

Энэ нь аудитыг хийж гүйцэтгэх хуулийн хугацаатай давхацсан тул аудитын баг шалгагдагч байгууллагын анхан шатны баримт авах болон биет тооллого хийх боломжгүй нөхцөл байдал үүссэн, ажлын тусгай горимоор ажилласан зэргээс шалтгаалан төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон 13 горим, сорилоос 9-ийг хэрэгжүүлсэн.

3.8 Аудитын гол асуудал

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд төсвийн захирагч мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний 23 байгууллага шилэн дансны цахим хуудсанд 2927 мэдээлэл байршуулахаас хугацаандаа 2849 мэдээлэл байршуулсан бол хугацаа хоцроосон болон цахим хуудсанд байршуулаагүй 78 мэдээлэл байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7 төлбөрийн акт, 17 албан шаардлага, 54 зөвлөмжийг 82.0 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт №9 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	7	4,592.9	6	4,583.0	86
Албан шаардлага	17	37,379.6	10	37,119.3	59
Зөвлөмж	54		48		89
Нийт дүн	78		64		82

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, чанарын баталгааны хугацаа дууссан, ашиглагч байгууллагад шилжүүлээгүй хөрөнгө бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа эсэхийг дараагийн аудитаар авч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 23 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба аудитад хамрагдсан байгууллагын 15 нь Зөрчилгүй, 3 нь Хязгаарлалттай санал, дүгнэлт авч, аудитын түүвэрт 5 тайланг хамруулсан байна.

4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 12,333.2 сая төгрөгийн 22 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй нийт 8,019.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,139.2 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 3,205.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 31 албан шаардлага хүргүүлж, 1,674.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 37 зөвлөмж өгсөн байна.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах талаар 1 зөвлөмж өглөө.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдол бүхий зөвлөмжийг оруулав. Үүнд:

Дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 8,019.0 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрснээс 3,139.2 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 3,205.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 31 албан шаардлага хүргүүлж, 1,674.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 37 зөвлөмж хүргүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

дд	Харьяа байгууллагууд	Дүгнэлтийн хэлбэр				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн ерөнхийлөн захирагч											
1	Засгийн газрын Хэрэг газар	1				0	-	0	-	1	-
Засгийн газрын тусгай сан											
1	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан		1			0	-	3	223.1	0	-
Төсөл хөтөлбөр											
1	Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн нэгж	1				0	-	1	-	1	-
2	Мэдээлэл харилцаа холбооны шинэчлэл төсөл					0	-				
2	ДҮН	1	-	-	-	0	-	1	-	1	-
Төрийн өмчит үйлдвэрийн газар											
1	Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ	1				0	-	1	70.8	2	-
2	Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ	1				1	3.9	1	-	1	0.5
3	Радио телевизийн сүлжээ ТӨҮГ	1				0	-	1	57.5	4	61.0
3	ДҮН	3	-	-	-	1	3.9	3	128.3	7	61.5
Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар											
1	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ	1				0	-	1	-	1	0.2
2	Төрийн ордны мэдээлэл үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ	1				0	-	2	10.2	2	-
2	ДҮН	2	-	-	-	0	-	3	10.2	3	0.2
Аж ахуй нэгж											
1	Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХХК	1				0	-	5	574.3	3	1.1
2	Монгол шуудан ХК	1				0	-	2	15.0	2	3.0
3	Монголын цахилгаан холбоо ХК	1				0	-	0	-	3	253.7
3	ДҮН	3	-	-	-	0	-	7	589.3	8	257.8
Төсвийн шууд захирагч											
1	Ерөнхий сайдын ажлын алба										
2	Шадар сайдын ажлын алба										
3	Засгийн газрын хэрэг эрхлэх газар										

4	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар УТҮГ		1			1	4.8	2	324.5	2	262.7
5	Төрийн түүхийн музей	1				0	-	2	6.2	1	6.5
6	Эдийн засгийн бодлогын зөвлөлийн ажлын алба										
7	Удирдлагын академи УТҮГ	1				0	-	2	-	1	-
8	Засгийн газрын авто бааз УТҮГ	1				0	-	2	63.4	1	-
9	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар		1			1	7.3	3	1,705.7	4	1,054.2
10	Үндэсний хөгжлийн газар	1				2	3,123.2	1	101.3	2	17.8
11	МОНЦАМЭ агентлаг	1				0	-	1	-	4	2.3
12	Үндэсний дата төв УТҮГ	1				0	-	1	53.0	2	11.8
12	ДҮН	6	2	-	-	4	3,135.3	14	2,254.1	17	1,355.3
24	НИЙТ ДҮН	16	3	-	-	5	3,139.2	31	3,205.0	37	1,674.8

6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

/сая төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Төр засгийн үйлчилгээг эрхлэх газар 2020 онд Ажиллагсдад олгосон тэтгэмж, урамшууллын 50.6 сая төгрөгийн орлогод албан татвар ноогдуулаагүй	4.8	Төлбөрийн акт	Дарга Нягтлан бодогч	Ж.Тамир Г.Нэрж Д.Ганчимэг
2	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар Барьцаа хөрөнгийн дансанд 2015 онд хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 7.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй	7.3	Төлбөрийн акт	Дарга Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ О.Наранбаатар
3	Үндэсний хөгжлийн газар Алтай-Дарви чиглэлийн 98км, 165 км хатуу хучилттай авто зам, Түнхэлийн төмөр бетон гүүр, Идэрийн голын хөвдөг гүүр төслийн техникийн хяналтаас хэмнэгдсэн 3,052.4 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй	3052.4	Төлбөрийн акт	Дарга Нягтлан бодогч	Х.Батжаргал М.Бямбахишиг
4	Үндэсний хөгжлийн газар Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэлт төслийн 70.0 сая төгрөг, Мандал сум Зүүн хараа чиглэлийн 15.8 км хатуу хучилттай авто зам төслийн 0.8 сая төгрөг, нийт техник хяналтын зардлаас хэмнэгдсэн 70.8 сая төгрөгийн арцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй	70.8	Төлбөрийн акт	Дарга Нягтлан бодогч	Х.Батжаргал М.Бямбахишиг
5	Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ Улсын төсөвт түрээсийн орлогоос төвлөрүүлэх 3.8 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн	3.9	Төлбөрийн акт	Захирал Нягтлан бодогч	Э.Цогтгэрэл Д.Цэрэндолгор
6	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар УТҮГ Тус газрын ажилтнуудын албан тушаалын цалин, нэмэгдлийг шинэчлэн батлахдаа " 20 хувиар нэмэгдүүлэн 2020 онд нэр бүхий 208 хүнд тооцож олгосон	324.5	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Ж.Тамир Г.Нэрж Д.Ганчимэг
7	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар УТҮГ 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын гүйлгээний мэдээллийг оруулаагүй /Нууц /	-	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Ж.Тамир Г.Нэрж Д.Ганчимэг
8	Төрийн түүхийн музей өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	6.2	Албан шаардлага	Музейн захирал Ерөнхий нягтлан бодогч	Н.Оюунтэгш Д.Цэцэгмаа
9	Төрийн түүхийн музей Тайлант хугацаанд оруулбал зохих 168 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл, хугацаа хоцроосон 29 мэдээлэл байна. 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тайланг мэдээлээгүй, мөн цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого санхүүжилтийн 14, зарлагын 2 гүйлгээний нийт 339,247.2 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.	-	Албан шаардлага	Музейн захирал нягтлан бодогч	Н.Оюунтэгш Д.Цэцэгмаа
10	Удирдлагын академи Шилэн дансны цахим системд байршуулах тайлант хугацааны 14 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	-	Албан шаардлага	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Сүрэнчимэг, С.Алтансүвд
11	Удирдлагын академи Захирлын тушаалаар балансын урамшууллыг нягтлан бодох бүртгэлийн ажилтанд хамаарахгүй нэр бүхий 6 ажилтанд олгосон	-	Албан шаардлага	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Сүрэнчимэг, С.Алтансүвд
12	ЗГБНҮГ Байгууллагын шилэн дансны цахим хуудаст 19 мэдээлэл хугацаа хоцроосон	-	Албан шаардлага	Захирал	Ө.Лувсанренчин

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	Засгийн газрын авто бааз УТҮГ Шилэн дансны мэдээллийг цаг тухайд иж бүрэн байршуулаагүй	-	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Г. Чинзориг Т. Урантогос
14	Засгийн газрын авто бааз УТҮГ Дансанд бүртгэлгүй хөрөнгөтэй холбоотой орлого олж, зардал гаргасан	63.4	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Г. Чинзориг Т. Урантогос
15	Засгийн газрын хэвлэх үйлдвэр шилэн дансны цахим хуудсанд 34 мэдээллийг хугацаа хоцроож, 70.8 сая төгрөгийн 12 мэдээллийг байршуулаагүй	70.8	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Б.Отгонбаяр Д.Нансалгарьд
16	Төрийн ордны мэдээлэл үйлчилгээний цогцолбор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй		Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Б.Туул Б.Батжаргал
17	Төрийн ордны мэдээлэл үйлчилгээний цогцолбор Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй	10.2	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Б.Туул Б.Батжаргал
18	Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн нэгж Шилэн дансны 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	-	Албан шаардлага	Төслийн зохицуулагч Нягтлан бодогч	Г.Нарангуа Б.Болор
19	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/151 тушаалаар албан хаагчдад Засгийн газрын тогтоосон хувь хэмжээнээс хэтрүүлэн 16.6 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон	16.6	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ О.Наранбаатар
20	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулалгүй нийт 1,501.5 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан, мөн 187.6 сая төгрөгийн тендер шалгаруулалтыг цахимаар гүйцэтгээгүй	1,689.1	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ О.Наранбаатар
21	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй	-	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ О.Наранбаатар
22	Үндэсний хөгжлийн газар худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулалгүй нийт 101.3 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан	101.3	Албан шаардлага	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Х.Батжаргал М.Бямбахишиг
23	МОНЦАМЭ агентлаг Байгууллагын шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын нийт 4 гүйлгээний мэдээлэл оруулаагүй	-	Албан шаардлага	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
24	Үндэсний дата төв УТҮГ Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй	53.0	Албан шаардлага	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	М.Баттулга Д.Сүглэгмаа
25	Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХХК "Аккумулятор нийлүүлэх" Топика ХХК-нь бараа нийлүүлэх 190.3 сая төгрөгийн гэрээний хугацааг сунгасан бөгөөд сунгасан гэрээг шинэчлэн байгуулаагүй, гүйцэтгэлийн баталгааны хугацааг сунгаагүй	190.3	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Ч.Золбаяр, Э.Энхтайван
26	Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХХК "Говь-Алтай аймгийн Цээл сумаас Алтай сум хүртэл шилэн кабелийн сүлжээ байгуулах ажил" МХС/202012025 тоот тендерийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тендер хүчинтэй хугацаанд байгуулаагүй	225.5	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Ч.Золбаяр, Э.Энхтайван
27	Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХХК "Видео хурлын тоног төхөөрөмж нийлүүлэх" МХС/202012031-1, 2020.04.14-нд Фэйд Трий ХХК 115.7 сая төгрөгөөр байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус	115.7	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Ч.Золбаяр, Э.Энхтайван

28	Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХХК “Баянгол дүүргийн 25-р эмийн сангийн уулзварын сувагчлал өргөтгөх” харьцуулалтын аргаар шалгаруулсан тендерийн үнэлгээний хороонд хараат бус гишүүнийг оруулаагүй	42.8	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Ч.Золбаяр, Э.Энхтайван
29	Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХХК Шилэн дансны хуулийн дагуу байршуулах мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	-	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Ч.Золбаяр, Э.Энхтайван
30	Радио телевизийн сүлжээ ТӨҮГ Шилэн дансны цахим хуудасны тулгалтаар 39 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан 57.5 сая төгрөгийн 6 мэдээллийг хугацаандаа байршуулаагүй	57.5	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Цагаанхүү Б.Батмөнх
31	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй	-	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ Т.Халиунаа
32	Өмнөх аудитаар өгсөн "барьцаа хөрөнгийн дансанд байршиж буй 9.9 сая төгрөгийг байгууллагад өгөх өглөгөөр бүртгээгүй, 2012 оноос хойш барьцаа хөрөнгийн дансанд байршсан" талаарх төлбөрийн актыг төлж барагдуулаагүй	-	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ Т.Халиунаа
33	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба байгуулан 199.6 сая төгрөгийн цалин, НДШ-д зарцуулсан, мөн нэр бүхий 10 ажилтанд 23.5 сая төгрөгийн урамшуулал олгосон	223.1	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ Т.Халиунаа
34	Монгол шуудан ХК 2020 оны шинэ жилийн арга хэмжээнд зориулж Мондактс ХХК-д 15.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч тус арга хэмжээ зохион байгуулагдаагүй байхад төлбөрийг буцаан авч тооцоог хийгээгүй	15.0	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал Санхүүгийн газрын дарга	Б.Анхбаатар Б.Наранцэцэг
35	Монгол шуудан ХК Шилэн дансны цахим хуудсанд 16 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан	-	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал Санхүүгийн газрын дарга	Б.Анхбаатар Б.Наранцэцэг
36	Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ Шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээлэл хугацаа хоцроосон	-	Албан шаардлага	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Э.Цогтгэрэл Д.Цэрэндолгор